



СОЁМБОМ

ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

МОНГОЛ УЛСЫНХАА ТӨЛӨӨ ЗҮТГЭЭ

МЭДЭЭ

№247 /456/

2022.01.16

Цаг үе, үйл явдал

ЭНХИЙГ САХИУЛАГЧДЫН АР ГЭРИЙН ТӨЛӨӨЛӨЛТЭЙ УУЛЗЛАА



Батлан хамгаалахын Ерөнхий хянан шалгагч бригадын генерал Ж.Болдбаатар, БХЯ-ны Стратегийн бодлого төлөвлөлтийн газрын дарга хурандаа Ч.Гандирваа болон бусад албаны хүмүүс оролцсон юм.

Энэ үеэр Батлан хамгаалахын сайд Г.Сайханбаяр хэлсэн үгэндээ "Дэлхийн хэмжээнд авч үзвэл

өнөөдөр биеллээ олж байна. Манай цэргийн алба хаагчид энхийг сахиулах ажиллагаанд оролцохдоо нэг зорилго, чиглэлийн дор өдөр шөнийг ялгалгүй тасралтгүйгээр үүрэг гүйцэтгэж байгаа. Харин ар гэрийн төлөөлөл та бүхэн хүү, хань, аав ээж,



Монгол Улс НҮБ-ын энхийг сахиулах ажиллагаанд оролцох багагүй туршлагатай орны тоонд багтдаг. Бид энхийг сахиулагч алба хаагчдаа дэлхийн халуун цэгүүдэд үүрэг гүйцэтгүүлэхээр илгээснээс хойш 21 жил өнгөрчээ. Энэ хугацаанд дэлхийн гурван тивд явагдсан энхийг сахиулах ажиллагаануудад манай улсаас давхардсан тоогоор 21000 гаруй цэргийн алба хаагч үүргээ нэр төртэй гүйцэтгэжээ. НҮБ-аас манай энхийг сахиулагчдыг маш өндөр үнэлдгийг энд уламжлахад таатай байна. Миний бие Батлан хамгаалахын сайдын албан тушаалд томилогдсоноос хойш энхийг сахиулах ажиллагааны орчин нөхцөлд дүгнэлт хийж, хэд хэдэн шинэчлэл хийх шийдэлд хүрсэн. Мөн энхийг сахиулагчдын ар гэрийн төлөөлөлтэй уулзах ёстой юм байна гэдэг дүгнэлтэд хүрсэн нь

ах дүүсийнхээ сэтгэл санааг үргэлж өргөж, дэмжиж, урмын үг хайрлаж байх ёстой юм шүү гэдгийг салбарын сайдын хувьд хэлмээр байна. Ар гэрь нь амгалан тайван байвал дэлхийн халуун цэгт үүрэг гүйцэтгэж байгаа цэрэг хүний хувьд хамгийн сайхан зүйл юм" хэмээн онцлоод, танхимд цугласан олонд хандан талархал илэрхийлж хамгийн сайн сайхныг хүсэн ерөөлөө. Мөн уулзалтад оролцогчдод зориулан ажиллагааны газар оронд үүрэг гүйцэтгэж байгаа XII ээлжийн цэргийн багийн үүрэг гүйцэтгэлтийн талаарх видео танилцуулгыг хүргэснээс гадна ЦДБЭЧ-ын хамт олон тоглолтоо сонирхууллаа.

Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Батлан хамгаалахын сайд Г.Сайханбаяр өнөөдөр Бүгд найрамдах Өмнөд Судан Улсад явагдаж буй НҮБ-ын энхийг сахиулах "UNIMISS" ажиллагаанд үүрэг гүйцэтгэж буй XII ээлжийн цэргийн багийн бие бүрэлдэхүүний ар гэрийн төлөөлөлтэй уулзалт хийж НҮБ-ын энхийг сахиулах ажиллагааны талаар болон монгол цэргүүдийн үүрэг гүйцэтгэлтийн өөрчлөлтүүдийн талаар мэдээлэл өглөө. Тус үйл ажиллагаанд ЗХЖШ-ын дарга бригадын генерал С.Ганбямба,



ЦАГ АГААР

УЛААНБААТАР

ӨДӨР	ШӨНӨ
-17	-30

ӨМНӨД СУДАН

ӨДӨР	ШӨНӨ
36	22

ВАЛҮТЫН ХАНШ

ВАЛҮТ	АВАХ	ЗАРАХ
USD	3.481	3.486
EUR	3.785	3.796
CNY	516	518
RUB	49.50	50.50
JPY	27.10	27.30
KRW	2.86	2.90

ЗУРХАЙ



2022.01.16 / ДАВАА ГАРАГ / БИЛГИЙН ТООЛЛЫН 24

ӨВЛИЙН ДУНД ХАР ХУЛГАНА САР
ЕСӨН УЛААН МЭНГЭТЭЙ ХӨХ НОХОЙ ӨДӨР

Үс засуулбал:
Өвчин эмгэг ирнэ
Наран ургах, шингэх:
08.36-17.27
Барилдлага:
Үхэх
Шүтэн барилдлага:
Тийн мэдэхүй

БАЙГАЛЬ, ЦАГ УУРЫН ХҮНД НӨХЦӨЛД МАРШ ҮЙЛДЭВ



болон гүйцэтгэл өндөр байж, "Эмнэлэг", "Химийн норматив", "Буудлагын дасгал боловсруулах", "Тактикийн ажиллагаа" гэсэн 4 цэгт үүрэг гүйцэтгэсэн юм.

Зэвсэгт хүчний 353 дугаар ангийн

мэдээлэл өгсний дараа цэргийн гэрээт болон хугацаат цэргийн алба хаагчдын сургалт бэлтгэлийн явц, орчин нөхцөл, байрлаж буй байр танхимуудыг танилцууллаа.



цэргийн гэрээт алба хаагчид Зэвсэгт хүчний 014 дүгээр ангид зочилж, үйл ажиллагаатай танилцлаа. Цэргийн гэрээт алба хаагчдад ангийн захирагчийн орлогч, захиргааны удирдлагын тасгийн дарга дэд хурандаа Л.Чинзориг ангийн түүхэн замналын талаар

Мөн инженерийн цэргүүдийн хэрэгжүүлж буй бүтээлч ажлуудыг онцлон тодотгож, цэргийн гэрээт алба хаагчаар улирч, Зэвсэгт хүчний эгнээнд элссэн түүрүүч, байлдагч нарт ажлын амжилт хүслээ.

БНМАУ-ын дагуу хугацаат цэргийн алба хаагчдын 30 км явган маршийг генерал Ж.Лхагвасүрэнгийн нэрэмжит, Цэргийн гавьяаны одонт Зэвсэгт хүчний 167 дугаар анги 2022-2023 оны сургуулийн жилийн цэргийн сургалт бэлтгэлийн төлөвлөгөөний хүндэрсэн нөхцөлд марш үйлдсэн ч сэтгэл зүйн бэлтгэл



КОРОНАВИРУС ДЭЛХИЙ ДАХИНД

Тохиолдол
Нийт: 671,376,056

Эдгэрсэн
Нийт: 642,723,293

Нас барсан
Нийт: 6,730,581

Цахим шууданд

“ЦАГААН СҮЛД”-ИЙНХЭН ЦАСАН ДЭЭР АМЬД ХӨГЖИМ ЭГШИГЛҮҮЛЛЭЭ



Зэвсэгт хүчний 032 ангийн “Офицеруудын зөвлөл”-өөс санаачлан Монгол Улсын Үндсэн хуулийн өдрийг тохиолдуулан Зэвсэгт хүчний 2023 оны аварга шалгаруулах Цэрэгжлийн спортын өвлийн хоёр төрөлт болон Цэрэгжлийн спортын цогцолборын өвлийн олон төрөлтийн тэмцээнд оролцох Зэвсэгт

хүчний нэгтгэл, ангиудын тамирчин дайчдын сэтгэл санааг өргөх, бэлтгэл сургуулийн үеийн биеийн дархлааг дэмжих, анги, салбараа сурталчлах зорилгоор цахилгаан хөгжмийн “Цагаан сүлд” хамтлаг ая дуугаа өргөлөө. Мөн энэ үеэр тус ангийн офицер, ахлагч нарын бүрэлдэхүүн урлагийн тоглолтоо

үзүүлсний зэрэгцээ тэмцээнд оролцож буй нийт тамирчдад халуун аарцаар үйлчилсэн юм.

Энэхүү ёслолын ажиллагааг нээж тус ангийн захирагчийн нэгдүгээр орлогч, штабын дарга дэд хурандаа Д.Хашхүү үг хэлж ангийн удирдлага болон нийт бие бүрэлдэхүүнийхээ өмнөөс спортын өндөр амжилт гаргахыг хүсээд хамт олны минь сэтгэл шингэсэн илгээмжийг хүлээн авч, хэсэг хугацаанд бидэнтэй хамт алжаалаа тайлж, дархлаагаа дэмжихийг хүслээ.

Ийнхүү “Цагаан сүлд” хамтлагийн залуус маань идэр есийн хүйтнийг ажралгүй нийт тамирчдадаа сэтгэл зүйн дэмжлэгийг үзүүлэхийн төлөө чин сэтгэл гарган амьд хөгжмийн тоглолтыг толилуулснаараа онцлог байлаа.

Мөн энэ үеэр ЗХЖШ-ын Сургалт бэлтгэлийн газрын Биеийн тамир, спортын тасгийн дарга, Монгол Улсын Гавьяат дасгалжуулагч, хурандаа Д.Цог-Эрдэнэ “Тамирчид бидэнд амжилт хүсэж, урам хайрлан хүрэлцэн ирсэн Зэвсэгт хүчний 032 дугаар ангийнхаа удирдлага, хамт олон, тэр тусмаа “Цагаан сүлд” хамтлагийнхаа хамт олонд цаначин дайчдынхаа нэрийн өмнөөс халуун баяр хүргэж, амжилт хүсье. Бидэнд амьд хөгжмийн аялгуу, амьд хоолой сонсож маш их сэтгэл гаргаж ирсэн Та бүхнийхээ энэ сайхан сэтгэлийг бид амжилтаараа, хүч чадлаараа, хурд хүчээрээ мялаах болно” хэмээн хэлсэн үгэндээ онцолсон юм.

Ахмад Т.ДЭЛГЭРМАА



АРТИЛЛЕРЧИД МАНЛАЙЛЛЫГ ӨӨРСДӨӨСӨӨ ЭХЛҮҮЛНЭ



2023 оныг Зэвсэгт хүчнээс “Залуу офицеруудын манлайллын жил” болгон зарласантай холбогдуулан Монгол Улсын баатар, хурандаа генерал Б.Цогийн нэрэмжит, Цэргийн гавьяаны одонт Зэвсэгт хүчний 120 дугаар ангийнхан алба хаагчдын өөртөө итгэх итгэл, манлайллыг

дээшлүүлэх хүрээнд олон арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлж байна. Үүний нэг нь 1 дүгээр сарын 13-ны өдөр зохион байгуулагдсан “Залуу офицер, ахлагч нарын манлайлал” сэдэвт төлөвлөлтийн хурал байв. Хурлаар офицер, ахлагч нар 2022-2023 оны сургуулийн жилд 5 бүлэгт

хуваагдаж, манлайллын ажлыг хэрэгжүүлэхээр тогтсон бөгөөд “Эрдэм мэдлэгтэй, эзэмшсэн мэргэжилдээ эзэн болж, эрхэлсэн ажилдаа харуцлагатай, манлайлагч болцгооё” хэмээх уриалгыг дэвшүүлэхээр санал нэгдлээ.

Энэхүү арга хэмжээ 1 дүгээр сарын 20-ны өдөр “Ангийн үйл ажиллагаанд залуу офицер, ахлагч нарын манлайлал нөлөөлөх нь” сэдэвт эрдэм шинжилгээний хурлаар үргэлжилнэ. Артиллерчид сургуулийн жилийн хугацаанд “Сургалт бэлтгэл, инновац”, “Цэргийн алба, биеийн тамир”, “Соёл урлаг, уран сайхан”, “Нийгмийн хамгаалал”, “Бүтээлч ажил” гэсэн таван бүлгийн хүрээнд манлайллыг хэрэгжүүлнэ.

Мөн тус ангийн хугацаат цэргийн алба хаагчдад “Монгол цэрэг-Бахархал” сэдвийн хүрээнд удирдах албан тушаалын офицер, ахлагч нар ярилцлага өрнүүлдэг уламжлалтай билээ.

Энэ өдөр ангийн ажиллагааны ахлагч, сургагч ахлагч Ч.Лхагважав “Амьдралынхаа гараагаа хугацаат цэргийн албанаас эхлүүлсэн билээ, би” дурсамж яриаг дэлгэж, сонгосон албандаа хэр сэтгэл хангалуун явдаг тухайгаа бахархал дүүрэн өгүүлэв.

Сургагч ахлагч Ч.Лхагважав хэлэхдээ “Би энэхүү нэр хүндтэй албыг хааснаараа амьдралын зорилготой болж, эх орноо батлан хамгаалах ариун

үүргээ нэр төртэй хааж байгаа билээ. Дайчид та бүхэн ч энэ сайхан албыг сахилга баттай, нэр төртэй хаана гэдэгт итгэл дүүрэн байна. Та бүхний өмнө олон боломж хүлээж байгаа” хэмээгээд цэргийн амьдралыг нь хүүрнэсэн зургийн цомгоо дэлгэж үзүүлсэн юм.

Мөн тэрээр хугацаат албаны дайчдад цэргийн гэрээт алба хаагч болон ахлагч, офицер болоход хэрхэн сурч боловсрох талаар мэдээлэл хүргэлээ.

Хошууч Ө.НАРАНТУЯА



Цахим шууданд

“И-МОНГОЛ АКАДЕМИ”-ААС...



ЗХЖШ-ын Үлгэр жишээ үлээвэр найрал хөгжимчдийн цахим ур чадварыг дээшлүүлэх зорилгоор “И-Монгол Академи”-ийн сургалтын хөтөлбөр хариуцсан мэргэжилтэн Х.Тайванцэцэгийг урьж “Мэдээллийн аюулгүй байдал” сэдвээр сургалт зохион байгууллаа.

Энэхүү сургалтаар хувийн мэдээллийн аюулгүй байдлын хамгаалалт, цахим гэмт хэргээс хэрхэн урьдчилан сэргийлэх талаар дэлгэрэнгүй мэдээллийг бие бүрэлдэхүүнд өгсөн юм.

Хошууч Б.ЦЭНГЭЛ

Зарлал

ЗӨВЛӨХ ИНЖЕНЕРИЙН СУРГАЛТ ЯВАГДАХ ГЭЖ БАЙНА

Монгол Улсын Батлан хамгаалахын сайдын тушаалаар Батлан хамгаалах салбарын цэргийн инженерийн мэргэжилтэнд мэргэшлийн зэрэг олгох, магадлан, итгэмжлэх зөвлөл байгуулагдаж, тус зөвлөлийн үйл ажиллагааны дүрэм, журам шинэчлэн батлагдлаа.

ҮБХИС-ийн ЦНДС-ийн Цэргийн инженер, химийн тэнхим, “Инженерийн цэргийн холбоо” ТББ хамтран мэргэшсэн болон зөвлөх инженерийн сургалтыг 2023 оны 1 дүгээр сарын 16-ны өдрөөс явуулахаар төлөвлөж байна.

Иймд мэргэшлийн зэрэг горилогчид дэлгэрэнгүй мэдээллийг /ҮБХИС-ийн <http://mndu.gov.mn> сайт болон 88076595, 99896595 дугаарт/ холбогдож авна уу.

Жич: Бүртгүүлэхээр ирэхдээ дараах материалыг бүрдүүлж ирнэ үү

Үүнд:

1. Зэрэг горилохыг хүссэн хувийн өргөдөл: Өргөдөлийг батлагдсан маягаар гаргана. /Өргөдөлийн маягыг нэгдүгээр хавсралтаар гаргана/
2. Ажил байдлын тодорхойлолт: Тодорхойлолтыг тухайн хүний үндсэн байгууллагаас тодорхойлж, удирдлага нь гарын үсэг зурж, тэмдэг дарж баталгаажуулсан байна. Шаардлагатай гэж үзвэл харъяалагдах дээд байгууллагын тодорхойлолт гаргаж болно.
3. 3x4 хэмжээтэй 2 хувь зураг/файлаар/
4. Дээд боловсролын үнэмлэх, дипломын хуулбар: Дээд боловсролын үнэмлэх, дипломын хуулбарыг нотариатаар баталгаажуулах, хэрэв баталгаажуулаагүй бол хуулбарыг эхтэй нь тулгаж хүлээж авна. /Гадаадад зэрэг хамгаалсан бол орчуулгын товчоогоор орчуулуулж, баталгаажуулсан байх/
5. Бүтээлийн тайлан, жагсаалт: Бүтээлийн тайлан жагсаалтыг үндсэн байгууллагын удирдах ажилтан ба зөвлөх зэрэгтэй хоёроос доошгүй мэргэжилтэн хянаж баталгаажуулсан байна. Бүтээлийн жагсаалтыг хоёрдугаар хавсралтаар гаргана. /Хүснэгтийн загвар доор бий/
6. Иргэний үнэмлэхний хуулбар/баталгаажуулсан байна/
7. Сургалт шалгаруулалттай холбогдсон төлбөрийн баримт: Төлбөрийг бэлнээр буюу дансаар төлж болно.